

МОНГОЛ, ЯПОНЫ ХАРИЛЦААНЫ ИДЭВХЖИЛ БА УЧИР ХОЛБОГДОЛ

*Т.Намжим**

Монгол улсын нийгэм, эдийн засагт 1980-аад оны сүүлийн хагас гэхэд харьцангуй өндөр хурдацтай ахиц дэвшил гарсан, нилээдгүй таатай нөхцөл байдал бүрэлдсэн урамтай цаг үе байсан билээ. Тэр үед улс орны нийгэм-эдийн засгийн хөгжлийн хэтийн төсөл, программ, үйлдвэрлэх хүчний хөгжил байршлын ерөнхий схем боловсрогдсон, тэдгээрийн дагуу цаашид улс орноо шинэлэг байдлаар хөгжүүлэх, түүний тулд эдийн засгийн гадаад харилцааны уламжлалт чиглэл хүрээг өргөтгөн тэлэх арга замыг хайж, юуны өмнө Япон улстай хамтын ажиллагаа явуулах нөхцөл боломжийг эрэлхийлэн тандаж эхэлсэн юм.

Анх удаагаа Монгол улсын Гадаад явдлын яамны сайд М.Дүгэрсүрэн 1987 оны 5 дугаар сард Япон улсад хийсэн айлчлалын яриа хэлцлийн явцад Япон улсын Ерөнхий сайд байсан дээд албаны хүн: хэрэв Монголын талаас хамтын ажиллагааны талаар тоймтой санал хүсэлтээ илэрхийлбэл Японы тал авч үзэж болох юм гэсэн утгатай зүйл хэлснийг манай тал ч анхааралтай тусгаж авсан хэрэг байв. Манай улсын хувьд хамгийн гол харилцаа болох эдийн засгийн хамтын ажиллагааг Япон улстай хэрхэн явуулах чиглэл, хэлбэрээ тоймлох, арга эвээ олох зэрэг асуудал тулгарч байсан билээ.

1. ЭДИЙН ЗАСГИЙН ХАРИЛЦААНЫ ИДЭВХЖИЛ

Монгол, Японы хооронд эдийн засгийн харилцааны эхлэлийг тавих талаар 1988-1990 онд яриа хэлцэл, ажил үйлс идэвхтэй явагдаж, зохих үр дүнд хүрсэн ололтыг хоёр улсын харилцааны салхийг хагалсан, хоёр орон харилцан бие биенээ нээсэн, эргэлт хийсэн үйл явц болсон хэмээн томъёолох явдал байдаг билээ. Юуны өмнө Япон улстай эдийн засгийн харилцаа хөгжүүлэх анхны тойм удирдамжийг Монгол улсын Төлөвлөгөө, эдийн засгийн

* Т.Намжим - академич

улсын хороо, Гадаад Хэргийн яам, холбогдох бусад яамдын мэрэгжлийн хүмүүсийн оролцоотой боловсруулсан бөгөөд улмаар тухайн үеийн ёс журмын дагуу МАХН-ын Төв Хороо, Сайд нарын Зөвлөлөөр зөвшөөрөн батламжилсан юм. Тэхэд энэ зүйлийг тэрлэгч Т.Намжим хэмээх хүмүүн Монгол Улсын сайд бөгөөд Төлөвлөгөө, эдийн засгийн хорооны нэгдүгээр орлогч даргын албыг хашиж байсан тул эрхэлсэн ажил үүргийнхээ дагуу уг үйл хэргийг толгойлон гүйцэтгэх шаардлага аргагүй тулгарсан билээ.

Тэгж байтал Япон улсаас Монгол улсад сууж байсан Элчин сайд Х.Такасэ, Зөвлөх М.Ханада /одоо Япон улсын Элчин сайд/ нар 1988 оны 9 дүгээр сард Т.Намжимтай уулзалт хийж, Япон улсын Засгийн газар мөн онд багтаан Японд айлчлахыг урьж байгааг уламжлан мэдэгдсэн бөгөөд бид ч уг урилгыг хүлээж авсан юм. Тэгээд Монгол улсын Засгийн газар Т.Намжим тэргүүтэй, мөн Геологи, уул уурхайн яамны дэд сайд Д.Рэнчинханд, Гадаад Хэргийн яамны ажилтан С.Хүрэлбаатар нарын бүрэлдэхүүнтэй төлөөлөгчийг Япон улсад явуулахаар шийдвэрлэсэн бөлгөө. Тийнхүү бидний хэдэн хүн Япон улсад 1988 оны 12 дугаар сард 10 хоногийн хугацаатай ажлын айлчлал хийж, Монгол, Япон хоёр улсын хооронд эдийн засгийн хамтын ажиллагааг харилцан ашигтай, урт хугацаанд тогтвортой байх зарчмын үндсэн дээр явуулж байх чиглэлийг баримтлан санал бодлоо солилцсон юм.

Тэрхүү айлчлалын явцад бид Японы төр засгийн албаны болон худалдаа үйлдвэрийн хүрээний хүмүүст дараахи салбар чиглэлээр хамтран ажиллах талаар өөрийн боломж, үндэслэл танилцуулж, санал бодлоо солилцсон юм. Тухайлбал:

- Геологи, уул уурхай, металл боловсруулалтын салбарт: Монгол орны эрдэс баялагийн хайгуул-үнэлгээний ажил хийх, үр ашигтай байж болох зарим орд газруудыг хамтран эзэмших, зэс, молбидены баяжуулалт, боловсруулалтын түвшинг ахиулах, технологийг шинэтгэн сайжруулах, зэс хайлах үйлдвэр байгуулах болон коксжих нүүрсний томоохон ордыг ашиглах боломжийг судлах, бага хүчин чадлын хар төмөрлөгийн үйлдвэр байгуулах болон коксжих нүүрсний томоохон ордыг ашиглах боломжийг судлах, бага хүчин чадлын хар төмөрлөгийн үйлдвэр байгуулах, металл эдлэхүүний үйлдвэрлэлийг өргөтгөх;

- Электрон хэрэгслийн салбарт, хөдөлгөөнт радио телефон холбооны аппарат, нарны зай, түүгээр ажиллах жижиг станц, электрон техникийн суурь материал, хэвлэмэл хавтан, бага оворын телевизор зэрэг зүйлсийн үйлдвэрлэл зохион байгуулах;
- Хөнгөн, хүнсний үйлдвэрийн салбарт: “Говь” комбинатыг өргөтгөх, сайн чанарын костюм зэрэг хувцасны оёдлын үйлдвэр, ариун цэврийн цаасны үйлдвэр зохион байгуулах малын цус, бусад дагавар түүхий эдээс өвөрмөц эм бэлдмэлийн зүйлс гаргаж авах биотехнологитой үйлдвэрлэл хөгжүүлэх;
- Дэд бүтцийн салбарт, хоёр улсын хооронд агаарын харилцааны шугам нээх, төмөр замын тээвэрлэн нэвтрүүлэх хүч чадлыг сайжруулах, сансарын холбооны станц байгуулах, аялал жуулчны баазыг өргөтгөн бэхжүүлэх;
- Боловсрол, эрүүлийг хамгаалахын салбарт: нарийн мэргэжлээр сургах оюутны болон мэргэжил дээшлүүлэх хүний тоог ихээхэн нэмэгдүүлэх, эмнэлгийн оношлогоо-эмчилгээний тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл нийлүүлэх зэрэг олон асуудлыг хамарч байсан болно.

Мөн тэр үед Япон-Монголын нийгэмлэгээс Монголын аль нэгэн хөдөө аж ахуйн нэгдлийг Монгол-Японы найрамдлын нэрэмжит болгож түүнд хөдөө аж ахуйн тоног төхөөрөмж нийлүүлж байх тухай санал болгож байсан билээ.

Тийнхүү манай талаас хамтын ажиллагааны олон тодорхой асуудал тавихын зэрэгцээ хамгийн гол зорилго бол Япон улсын “Хөгжлийн албан ёсны тусламж” /Official development assistance ODA/ -ийн хүрээнд Монгол улс багтаж орох асуудал байсан бөгөөд энэ талаар бид Японы Гадаад хэргийн яамны дэд сайд, Азийн газрын дарга нарт болон Парламентын хоёр танхимын удирдах хүмүүст хүсэлтээ тавьсан юм. Тэгэхэд Японы Гадаад хэргийн яамны дээд албаны хүмүүс манай улсад Японы Засгийн газрын буцалтгүй тусламж, хөнгөлттэй зээл олгох асуудалд нааштай хандаж, судлаж үзье гэсэн хариу өгч байсан болно. Парламентын Төлөөлөгчдийн танхим дахь Япон-Монголын найрамдлын бүлгэмийн дарга Т.Хасгева, Зөвлөхүүдийн танхим дахь мөн найрамдлын

бүлгэмийн дарга Ю.Осада нар Монгол улсыг Японы Засгийн газрын буцалтгүй тусламжийн хүрээнд оруулах, тусламж үзүүлэх талаар Засгийн газартаа нөлөөлж ажиллана гэж мэдэгдээд, хоёр улсын хамтын ажиллагааны талаар бидний ярилцсан асуудлын жагсаалтаа өгөхийг хүсэлт болгож байсан билээ.

Тэхэд бид томоохон үйлдвэрийн газар барьж байгуулахад Японы банкны зээл авах боломжийг тандаж судласан бөгөөд Японы Экспорт-импортын банкны удирдах хүмүүстэй уулзаж зээл олгодог журам, нөхцлийн тухай ярилцаж, хэрэв Монгол улс японы компаниудтай тодорхой объект барьж байгуулахаар тохиролцвол тус банкнаас зээл олгож болох, улмаар Хар төмөрлөгийн үйлдвэрийг тус банкны зээлээр бариулах боломжийн талаар санал солилцсон болно. Тэгээд Дарханы хар төмөрлөгийн үйлдвэрийг барихад Японы Экспорт-импортын банкнаас жилийн 5,6 хувийн хүүтэй, 5 жилийн хугацаатай долларын зээлийг тус үйлдвэрийн өөрийнх нь бүтээгдэхүүнийг болон зэсийн баяжмал, ноолуур, түүгээр хийсэн эдлэхүүнийг Японд нийлүүлэх арга замаар эргүүлж төлөхөөр тохиролцсон билээ. Энэ бол харьцангуй аятайхан нөхцөлтэй зээл байсан юм.

Бидний айлчлалын нэг гол зорилго бол Монгол улсад эдийн засгийн арга механизмын өөрчлөлт шинэтгэл явагдаж байгаа, Монгол улсын Засгийн газар өрнөдийн орнуудтай, ялангуяа Япон улстай бүх талын хамтын ажиллагаа явуулах, хоёр улсын харилцааг шинэ шатанд гаргах бодлого зорилготой байгаагаа японы талд ойлгуулах явдал байсан билээ. Тэрхүү анхны оролдлого, үйл явдал нь хоёр талдаа харилцан ойлголцох, ялангуяа японы тал манай байдлыг таньж мэдэхэд тус дэм болсон байж магадгүй юм. Учир нь бидний айлчлалын хариу болгож, нутаг буцах үед Япон улсын Гадаад хэргийн сайд С.Уно гуай Монголын төлөөлөгчийн тэргүүн Т.Намжмын нэр дээр өгсөн албан бичигтээ өөрийн талын хандлагыг илэрхийлсэн зүйлээс тодорхой байдаг юм.

Тэрээр уг албан бичигтээ:

“Сүүлийн жилүүдэд танай улсад дотоодын эдийн засгийн шинэчлэлийг зохион байгуулж эхлэснийг мэдэж байна.Тэр эдийн засгийн шинэ механизм байгуулах ажил үр дүнтэй болж, танай улс улам хөгжин цэцэглэхийг хүсч байна.

Таныг сая Япон улсад айлчлах үеэр манай Засгийн газрын болон бусад холбогдох хүмүүстэй уулзан санал бодлоо өргөн хүрээтэйгээр солилцсоныг мэдэж байна. Танай улсыг хөгжүүлэхэд манай Засгийн газрын хувьд ямар салбарт хамтран ажиллах боломжтойг үргэлжлүүлэн идэвхитэй судлах бодолтой байна.

Эрхэмсэг ноён Таны манай улсад айлчилсан энэ удаагийн айлчлал нь манай хоёр улсын хоорондох харилцааг цаашид улам хөгжүүлэхэд түлхэц болно гэдэгт найдаж байна.

Цаашид гадаад харилцааны бусад арга хэмжээний хөтөлбөрөө харгалзан үзэж БНМАУ-д айлчлах бололцоогоо судлан үзье” хэмээн бичсэн байж билээ. Тэгэхээр энд дурьдсан албан бичгээс үзвэл 1988 он гэхэд Японы Засгийн газрын албаны хүмүүс Монгол улсад эдийн засгийн өөрчлөлт шинэтгэл явагдаж байсныг хүлээн зөвшөөрсөн, тэрхүү үйл хэрэг нь Монгол орны хөгжил дэвшилд болон хоёр улсын хамтын ажиллагаанд таатай нөлөө хамааралтай болно гэдэг итгэл найдварыг японы талд төрүүлж байсны нотолгоо болсон хэрэг байв.

Биднийг Японд айлчлахаар явдаг өдөр манай Гадаад Явдлын яамны сайд Ц.Гомбосүрэн Японы Гадаад хэргийн сайд С.Уног Монгол улсад айлчлах урилгыг тэр үед манай улсад сууж байсан Японы Элчин сайд ноён Такасэ-д гардуулсан юм. Тэгээд Японы Гадаад хэргийн сайд С.Уно манай улсад 1989 оны 5 дугаар сард айлчилсан нь Япон улсын, ер нь өрнөдийн орны Гадаад хэргийн сайд Монгол улсад анх удаа айлчилсан үйл явдал болсон билээ. МАХН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Монгол Улсын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга Ж.Батмөнх, Сайд нарын Зөвлөлийн дарга Д.Содном нар С.Уно сайдыг хүлээн авч уулзсан, тэр айлчлал туйлын ажил хэрэгч, элэгсэг дотно болж өнгөрсөн билээ.

Мөн оны 8 дугаар сард ноён Т.Акияма тэргүүтэй Японы Засгийн газрын эдийн засгийн төлөөлөгчийг манай тал хүлээн авч хоёр улсын эдийн засгийн харилцааны асуудлаар санал бодлоо солилцсон нь хоёр тал харилцан ойлголцох, таньж мэдэхэд ихээхэн ач холбогдолтой арга хэмжээ болсон юм.

Монгол, Япон хоёр улсын хооронд эдийн засгийн харилцааны эхлэн тавигдах, идэвхжин өргөжихөд 1989 оны эхээр бүрэлдэн

байгуулагдсан Монгол-Японы эдийн засгийн харилцаа эрхлэх комисс чухал үүрэг гүйцэтгэсэн болно. Урьд нь Монгол-Японы эдийн засгийн харилцааны комисс гэж байсан боловч бүтэн 7 жилийн хугацаанд Японы талтай хамтарсан уулзалт, хурал хийгээгүй, ямар ч ажил үйлс явуулаагүй байсан юм. Тэгээд 1989 оны 9 дүгээр сард Улаанбаатар хотноо Монгол-Японы эдийн засгийн комисс, Япон-Монголын эдийн засгийн хорооны хамтарсан хуралдаан болж, түүнд Японы талын хорооны дарга С.Тозаки тэргүүтэй, хорооны гишүүд, нийтдээ 50-иад хүний бүрэлдэхүүнтэй төлөөлөгчид оролцсон юм. Тэр хуралдаанд анх удаа Япон улсын Засгийн газрын албан төлөөлөгч буюу Япон улсаас Монгол улсад суугаа Элчин сайд нь оролцсон болно. Тус хуралдаанд Монголын талаас улс орныхоо эдийн засгийн хөгжлийн тухайн үеийн байдал, цаашдын гол зорилт, Монгол, японы хооронд эдийн засгийн хамтын ажиллагаа явуулах боломжийн талаар, Японы талаас Азийн бүс нутгийн орнуудтай эдийн засгийн харилцаа хөгжүүлдэг, тусламж дэмжлэг үзүүлдэг арга туршлагынхаа тухай мэдээлэл хийсэн, хоёр талын төлөөлөгчид сонирхсон асуудлаар харилцан асуулт, хариулт сонсож, санал бодлоо ярилцсан билээ. Мөн хуралдааны үеэр Японы барааны үзэсгэлэн зохион байгуулагдсан нь ихээхэн анхаарал татсан арга хэмжээ болсон билээ.

Тэхэд Япон-Монголын эдийн засгийн хорооны дарга, Иточү корпорацийн хүндэт ерөнхийлөгч Сейки Тозаки гуай анх удаа Монголд гэргийн хамт айлчилж, дээрх бүх арга хэмжээг бидэнтэй хамтран явуулсан юм. Тэрээр Монгол-Японы Эдийн засгийн харилцааны комисс, Япон-Монголын Эдийн засгийн хорооны хуралдаанд оролцоод буцсаныхаа дараа хоёр улсын харилцааны асуудлаар манай талд тусгайлан захидал бичиг ирүүлсэн байв. Уг захидал бичгийг бүрэн эхээр нь толилуулах аваасу:

1989 оны 10 дугаар сарын 12
Улаанбаатар, БНМАУ

Эрхэмсэг ноён, доктор Төмөрийн Намжим танаа
Монгол-Японы эдийн засгийн комиссын дарга,
БНМАУ-ын сайд, Төлөвлөгөө, эдийн засгийн
Улсын хорооны нэгдүгээр орлогч дарга

Эрхэмсэг ноён,

Монгол-Японы эдийн засгийн комисс, Япон-Монголын эдийн засгийн хорооны хамтарсан 3-р хуралдаан болон мөн өнгөрсөн сард Улаанбаатар хотноо болсон Японы барааны үзэсгэлэнд оролцсон намайг болон манай нөхдийг Улаанбаатар хотод байх хугацаанд сайхан хүлээн авч хамтран ажилласан явдалд Танд чин сэтгэлийн талархал илэрхийлэхэд таатай байна.

Ихээхэн чухал ач холбогдол бүхий дээрх арга хэмжээнүүд амжилттай хэрэгжлээ гэж би үзэж байна. Хамтын ажиллагааны өргөн хүрээний асуудлаар харилцан санал, мэдээлэл солилцсон явдал нь манай хоёр орны худалдаа, эдийн засгийн харилцааг цаашид өргөжүүлэхэд хувь нэмрээ оруулна гэдэгт итгэж байна.

Манай хоёр орны Засгийн газрын хооронд болон хоёр орны сонирхсон байгууллагуудын хүрээнд хэлэлцсэн тодорхой асуудлууд нь ойрын ирээдүйд хэрэгжих болно гэдэгт найдаж байна.

Мөн Эрхэмсэг ноён Д.Содном Япон улсад айлчлах тухай Японы Засгийн газрын урилгыг хүлээн авсан явдалд би туйлын их баяртай байна. Би болон Япон-Монголын эдийн засгийн хорооны гишүүд Эрхэмсэг ноён Ерөнхий сайд Содномын морилон ирэхэд чин сэтгэлээсээ талархаж байгаа бөгөөд түүнтэй уулзан учрахыг хүлээж байна. Түүний айлчлал нь үр дүнтэй бөгөөд амжилттай болж, Япон, Монголын хоорондын цаашдын харилцаанд тус дөхөм үзүүлнэ гэдэгт итгэл төгс байна.

1990 онд Токиод болох ээлжит хамтарсан хуралдаанаар уулзахаас өмнө манай хамтын ажиллагаанд тодорхой дэвшил гарвал би туйлын баяртай байх болно.

Хамтран ажиллаж байгаа явдалд танд дахин талархалаа илэрхийлье.
Хамгийн сайн сайхныг хүсье.

Гүн хүндэтгэсэн,

Сейки Тозаки.

Япон-Монголын эдийн засгийн хорооны Ерөнхийлөгч

Хэдийгээр энэ захидалд дурьдсанчлан 1989 оны 9 дүгээр сард болсон хамтарсан хуралдааныг 3 дугаар хуралдаан гэж нэрлэсэн боловч өмнөх хуралдаанаас хойш даруй 7 жил өнгөрсөн, тэр хугацаанд эдийн засгийн харилцаанд огт ахиц гараагүй, ажил хэрэг болсон ямар нэгэн зүйл байхгүй Япон-Монголын эдийн засгийн хорооны дарга нь ч Монголд ирж үзээгүй байсан юм билээ. Тийм учраас 1989 онд болсон Монгол-Японы эдийн засгийн комисс, Япон-Монголын эдийн засгийн хорооны хамтарсан хуралдаан нь ажил хэрэгч байдал, үр дүнгээрээ бол үнэн чанартаа анхны хуралдаан байсан гэж үзэж болно.

Үнэхээр Монгол, Япон хоёр улсын хооронд эдийн засгийн харилцааг өргөжүүлэх эхлэлийг тавих талаар 1989-1990 онуудад тун идэвхитэй үйл ажиллагаа явагдсан юм. Тухайлбал, зөвхөн 1989 оны сүүлч, 1990 оны эхний улиралд эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагааны асуудлаар Монгол улсын Төлөвлөгөө, эдийн засгийн улсын хороо болон Монгол-Японы эдийн засгийн харилцааны комиссын шугамаар Японы яам газрууд, корпораци, компаний албаны хүмүүстэй болон Улаанбаатарт суугаа Японы Элчин сайдтай 12 удаа ажил хэргийн уулзалт хийж хамтын ажиллагааны олон асуудлыг ярилцаж шийдвэрлэсэн буюу цаашдын арга замын талаар зөвлөлдсөн ярианы тэмдэглэл эдүгээ байдаг юм.

Монгол-Японы хооронд харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэхэд Монгол улсын Ерөнхий сайд Д.Содномын 1990 оны 3 дугаар сарын эхээр Япон улсад хийсэн айлчлал ихээхэн үр нөлөөтэй болсон билээ. Монгол улсын Ерөнхий сайд Д.Содномын айлчлалын гол дүн бол Японы Засгийн газрын буцалтгүй тусламжийн хамтын ажиллагаа, мөн засгийн газрын батлагаатай банкны зээл, худалдааны даатгал гэсэн эдийн засгийн хамтын ажиллагааны гурван шинэ хэлбэрийн эхлэлийг тавьсан, Монгол, Япон хоёр улсын Засгийн газар хооронд худалдааны хэлэлцээр байгуулагдсан явдал байсан юм.

Түүнчлэн Монголын Ерөнхий сайдын анхны айлчлал нь Монгол орноо Японы ард түмэнд таниулах, ойлгуулахад тус дэмтэй арга хэмжээ болж өнгөрсөн бөгөөд түүнд уг айлчлалын бас нэг чухал ач холбогдол агуулагдаж байв. Тэр үед Япон улсаас Монгол улсад сууж байсан Элчин сайд Х.Такасэ 1990 оны 3 дугаар сарын 16-нд Ерөнхий сайдын айлчлалын төлөөлөгчийн бүрэлдэхүүнд орж явсан Засгийн газрын гишүүн Т.Намжимтай

уулзалт хийж, уг айлчлалын талаар дараахи зүйлийг ярьсаныг сийрүүлэн толилуулбал:

"Сайд нарын Зөвлөлийн дарга Д.Содномын айлчлал амжилттай сайхан боллоо. Содном дарга олон хүнтэй, ялангуяа хэвлэл мэдээллийн хүмүүстэй уулзаж, сонирхсон янз бүрийн олон асуудалд бодитой үнэн хариулт өгч ярилцсан явдал нь Японы ард түмэн Монгол улсыг үнэн зөвөөр ойлгоход ихээхэн ач холбогдолтой үйл явдал боллоо. Манай ард түмэн Монгол улсын талаар их өргөн ойлголттой болж, сайн сэтгэгдэлтэй үлдсэн гэж үзэж байна. Айлчлалын үеэр радио телевизийн "ИНК" компани 2 удаа нэвтрүүлэг явуулсан. Мөн "ТBS" компани 15-20 минутын тусгай нэвтрүүлэг бэлтгэж явууллаа. Үүнээс гадна сонин хэвлэлд маш өргөн нийтлэгдсэн. Одоо ч гэсэн айлчлалын талаар хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр сурталчилж байна" гэж ярьсан уулзалтын тэмдэглэл байдаг юм.

Тийнхүү Япон улсад хийсэн хоёр удаагийн айлчлалын болон Монгол, Япон улсын эдийн засгийн харилцааны комисс, хорооны хамтарсан хуралдааны үеэс эхлэн 1989-1990 онуудад санал болгож байсан олон арга хэмжээ эдүгээ ихэвчлэн хэрэгжсэн, үргэлжлэн гүйцэлдэж буй, бас ирээдүйн төлөв ч аятай байгаа явдалд сэтгэл таатай байдаг юм.

Монгол, Японы хамтын ажиллагаанд болсон хамгийн анхны томоохон арга хэмжээ бол Хар төмөрлөгийн үйлдвэр байгуулсан явдал мөн билээ. Жилдээ нэг бум тонн төмөр хайлуулах, металл хийц бэлтгэх үйлдвэртэй болно гэдэг бол хөгжиж буй орны хувьд улс үндэстний бахархалын том асуудал байсан юм. Уг үйлдвэрийг барьж байгуулахад Японы Экспорт-импортын банкнаас зээл олгохоор болж, уг зээлд Японы Засгийн газраас Монголын талд баталгаа гаргаж өгсөн явдал чухал арга хэмжээ болсон билээ.

Энд нэг онцлон дурьдамаар нөхцөл байдал бол хэдийгээр манай уламжлалт өргөн харилцаа, хамааралтай байсан хуучны ЗХУ-ын нам, төрийн дээд албаны хүмүүс хар төмөрлөгийн үйлдвэрийг Япон улстай хамтран байгуулах асуудалд таатай бус хандлагатай байсан боловч тэр үед манай улсын нам, төрийн тэргүүн асан Ж.Батмөнх, мөн Засгийн газрын Ерөнхий сайд асан Д.Содном нар уг арга хэмжээг Японы талд тавих бодлогыг тууштай баримтлан, бидний саналыг дэмжиж байсан явдал юм.

Дарханы Хар төмөрлөгийн үйлдвэр бол улсын хөрөнгө оруулалт болон гадаадын зээлийн хөрөнгөөр баригдсан, төрийн

өмчтэй, манайдаа цоо шинэ чиглэлийн томоохон хэмжээний үйлдвэр гэдэг нь ойлгомжтой байв. Гагцхүү түүнийг 1994 онд ашиглалтанд орох үед Засгийн газраас эргэлтийн хөрөнгө олгоогүй, ер нь олигтой анхаарал тавиагүй бололтой байдаг. Түүнчлэн уг үйлдвэрийг барьж байгуулсан, ашиглалтанд оруулсан, улмаар ажиллуулж байгаа бүхий л он жилүүд нь Монгол орны эдийн засаг уналтанд орсон, зохицуулалтгүй болж учир замбараагаа алдсан эмгэнэлт цаг үетэй давцсан явдал нь манай хоёр улсын хамтын ажиллагааны хамгийн анхных гэж хэлж болохоор тэрхүү чухал объектын үр ашигт туйлын муугаар нөлөөлсөн нь мэдээж хэрэг юм. Үүнийг тэрлэгч хүмүүн 1996 оны зун Дарханд очиж, уг үйлдвэртэй танилцахад анх ашиглалтанд орохдоо эргэлтийн хөрөнгөгүй, банкны зээлээр үйлдвэрлэлээ эхлэсэн, захирал нь хэдэн удаа солигдсон, цахилгааны төлбөрөө хийж чадахаа больсон, хэдийгээр бүтээгдэхүүний гадаад, дотоод зах зээлийн эрэлт хэрэгцээ хүчин чадлаас нь давж байсан боловч ажилгүй сул зогсож байхыг үзээд туйлын их харамсал төрж билээ. Бидний анхны санал төслөөр бол тус үйлдвэрийн хоёр дахь ээлжинд Дарханы ойролцоох төмрийн хүдрийн орд газрыг эзэмшин ангижруулсан төмөр бэлтгэж түүхий эдийн найдвартай баазтай болгох асуудал байсан билээ. Энэ бол зайлшгүй шийдвэрлэх, хэрэгжүүлэх шаардлагатай чухал арга хэмжээ байсан юм. Гагцхүү уг асуудлыг шийдэх байтугай ярих ч сөхөөгүй байсаар нилээн асуудлыг хөнгөвчлөх, болж үзвэл шийдвэрлэх, гадаад хамтын ажиллагаа явуулах боломжийг бүрэлдүүлэх, ер нь нийгмийн амьдралд бодитой хувь нэмэр болох чиглэлийг сонгох, судлан үзэх үндсэн дээр дорвитойхон тусламж дэмжлэг үзүүлж байгаа нь онцлог юм. Товчлон хэлбэл, Монгол орны нийгэм, эдийн засаг уналт, хямралд орсон 1990 оноос хойших 10 гаруй жилд манай орны аль хүндрэл бэрхшээлтэй болсон бүхий л салбар, газар нутагт Япон улсын үзүүлж байгаа олон янзын тусламж дэмжлэг нь эдүгээ авралын гол хүчин зүйл болж байна.

Монгол, Японы хоорондох эдийн засгийн харилцааны идэвхжлийн нэг гол илрэл бол мөн 1989 оноос гадаад худалдааны эргэлт ихээхэн нэмэгдэж эхлэсэн явдал юм. Тухайлбал, манай хоёр орны хоорондын гадаад худалдааны эргэлт 1989 онд 31,4 сая доллар хүрсэн нь 1987 оныхоос 2,8 дахин нэмэгдсэн байлаа. Харин Монголын эдийн засгийн гэнэтийн их хямралаас болж 1990-1991 онуудад эргээд 2 дахин буурсан боловч дараагийн

хэдэн жилд өсөн нэмэгдсээр 1999 оны байдлаар Монгол, Японы гадаад худалдааны нийт эргэлт 126 сая шахам долларт хүрч гадаад худалдааны харилцаатай байгаа 23 орны дотор ОХУ, Хятад улсын дараа гуравдахь байранд, импортын хувьд ОХУ-ын дараа хоёрт орсон байв.

Мөн хоёр орны хооронд аялал жуулчлал хомс буюу 1980-аад онд Японоос Монголд ирж байсан жуулчдын тоо ердөө л 200-300 орчим байсан бол нисэх онгоцны шууд харилцаатай болж Японы жуулчдын тоо сүүлийн үед жилдээ 1 түмээс давах болсон байна. Гагцхүү манай олон улсын шугаманд нислэг хийж байгаа одоогийн онгоц, түүний үйлчилгээний чанар базаахгүй байгааг анхаарах нь зүйтэй байгаа юм.

Эдүгээ манай хоёр орны хооронд жинхэнэ ардын дипломат харилцаа өргөжин тэлж байна. Японы жирийн олон түмний зүгээс Монгол оронд монголын хүн ардад тун элэгсэг дотно ханддаг, монголын түүх, соёл иргэншлийг сонирхон үздэг явдал байнга мэдрэгдэж байдаг болжээ.

Японы хэдэн арван муж, хотуудад Япон, Монголын найрамдлын нийгэмлэг, холбоо байгуулагдаж орон нутаг, хүн ардын хооронд олон нийтийн харилцаа өргөжиж байна. Танта хотын Монголын угсаатны зүйн музейг жилд 5 түм орчим япончууд очиж үздэг нь тун сонирхолтой тоо баримт юм. Мөн Кюүшо арлын Нагасаки мужийн Такашима хотод Хувилай хаанд зориулсан музей, хөшөө, 30-аад гэртэй монгол тосгон байдаг бөгөөд мөн л тэнд жилдээ хэдэн түмэн хүн очдог ажээ.

Осака хотод байдаг Япон-Монголын эдийн засаг, соёлын харилцааны нийгэмлэг, түүний тэргүүн хатагтай Сато Норико бол хоёр улсын харилцааны талаар байнгын ажил үйлсийг уйгагүй явуулж байдаг хүн юм. Тэрээр хэдэн жилийн өмнөөс Монголын өргөмжит консул болсон билээ. Монгол, Японы өнөөгийн харилцааны өргөн цар хүрээтэй, олон төрлийн үйл хэргийн талаар энд бүхэлд нь тоочин үгүүлэх боломжгүй нь ойлгомжтой юм.

2.МОНГОЛ, ЯПОНЫ ХАРИЛЦААНЫ УЧИР ХОЛБОГДОЛ

Сүүлийн жилүүдэд манай хоёр улсын хооронд харилцаа, хамтын ажиллагаа овоо гайгүй өргөжөөд ирэхээр манай монголын зарим хүмүүс сэтгүүлчид хоёр улсын төр засгийн үйл ажиллагаа болон жирийн олон түмний найрсаг хандлагын талаар “цаанаасаа далдын чиг бодлоготой” явагдаж буй мэтээр сонин хэвлэлд хардаж

сэрдсэн байдалтай зүйл нийтлүүлэх, мөн монголын хүн ардын дунд төөрөгдөл үүсгэж болзошгүй элдэв цуу яриа гарах явдал мэр сэр ажиглагдаж байсан билээ.

Тиймэрхүү болчимгүй яриа үнэмшил аяндаа тархаж хүн ардын дунд буруу зөрүү ойлголт хэвшил болох, улмаар хоёр орны харилцаа, хамтын ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлэх явдлаас сээрэмжлэх, олон түмэндээ бодит байдлыг үнэн мөнөөр нь таниулах зорилгоор манай хоёр улсын харилцааны учир шалтгааны тухай зохиогч урьд нь бас сонин хэвлэлд нийтлүүлж байсан бөгөөд эдүгээ Монгол, Япон хоёр улсын хооронд албан ёсны дипломат харилцаа тогтоосны 30 жилийн ойг тохиолдуулан ийнхүү давтан үгүүлсэн хэрэг болой.

Сүүлийн жилүүдэд Монгол, Япон хоёр улсын хооронд харилцаа, хамтын ажиллагаа илэвхжин өргөжсөн, улмаар Япон улсын зүгээс ахиухан тусламж дэмжлэг үзүүлж байгаа нь гурван талын үндсэн учир холбогдолтой байгаа билээ.

Нэгдэх учир холбогдол нь дэлхий дахины нийтлэг үйл явц, олон улсын харилцааны нөхцөл байдалтай хамаарал холбоотой байна. Дэлхийн II дайны дараахан НҮБ бий болж, түүнээс хойших 50-иад жилийн дотор энэ хорвоо ертөнцийн олон улс үндэстнүүд хоорондоо ойртон нягтрах, найрсаг харилцаатай болох нийтлэг үйл явц явагдсан, мөн 1980-аад оны сүүлч, 1990-ээд оны эхээр хуучны социалист орнуудад нийгмийн байгуулалын тогтолцоо халагдаж өөрчилөгдсөн явдал нь дэлхийн улс орнуудын харилцаанд шинэ нөхцөл байдлыг бүрэлдүүлсэн бөгөөд улмаар дорвитой түлхэц болсон билээ. Дэлхий нийтийн энэ үйл явц, нөхцөл байдал нь аяндаа Монгол, Япон хоёр улсын хооронд харилцаа, хамтын ажиллагаа өргөжин хөгжих нэг гол учир шалтгаан, суурь дэвсгэр болсон нь хэн бүхэнд ойлгомжтой байгаа болов уу. Тийнхүү ХХ зууны хоёрдугаар хагас дахь олон улсын харилцааны нэгэн нийтлэг бодит зүйл бол тэртээ тив дэлхийг хамарсан их дайны үед харилцан дайтаж, олон сая хүний амь насыг бүрэлгэж хот тосгодоо сүйтгэж байсан өдий төдий олон арван улс орнуудын хооронд эдүгээ улс төр, эдийн засаг, соёл, хүмүүнлэгийн зэрэг бүх талын харилцаа тогтож, нэгэн эвсэл холбоонд нийлэн нэгдэж бүр холбоотон, хэзээний түншүүд болцгоосон явдал юм. Тийм нийтлэг жишээг маш олноор нь дурьдаж болно. Тэртээ дэлхийн II их дайны үед ЗХУ, Герман хоёр бүтэн дөрвөн жилийн турш хэрхэн байлдаа,

Герман улс яаж Франц болон Европын олон улс орныг түрэмгийлэн эзэлсэн, АНУ-ын арми дэлхийн II дайны төгсгөлд мөн Германы баруун талын хотуудыг болон Японыг хавтгайлан бөмбөгдсөн, бүр хүн ам олонтой хоёр хотод атомын аймшигт бөмбөг дэлбэлсэн билээ. Гэтэл эдгээр бүх орнууд цөм өөр хоорондоо найрамдалт харилцаатай холбоотнууд болцогоосон байгаа явдал нь өөрөөр байх аргагүй, нийтлэг зүй тогтолтой үйл явц болж байна.

Тэгвэл Монгол, Япон хоёр улсын хувьд ч гэсэн мөн тэртээ жараад жилийн өмнө хэсэгхэн хугацаанд дайн тулааны байдал байсныг эдүгээ байнга л дурсан санагалзаад байвал найрсаг харилцаатай болоход төвөгтэй байх бөгөөд тэгсэнээрээ дэлхий дахинаа энх тайвнаар оршин амьдрах хүн төрөлхтний нийтлэг хувь тавилангаас ангид үл ойлгогдох, хачирхалтай этгээд хэрэг явдал болохсон билээ. Тийм болохоор Монгол, Япон хоёр улс үндэстний хооронд найрсаг харилцаа, хамтын ажиллагаа өргөжин хөгжиж байгаа нь мөн л дэлхий дахинд бий болсон нийтлэг жам ёс, зүй тогтлын дагуу явагдаж буй хэвийн үйл явц мөн болов уу хэмээн бодох юун.

Хоёрдахь учир холбогдол нь манай Монголын талын нөхцөл байдлаас хамааралтай байна. Монгол улс 1980-аад сны сүүлчээс эхлэн гадаад харилцааны олон чиглэл бүхий нээлттэй бодлого, үйл ажиллагаа явуулах болсон, улмаар тэр хүрээндээ Япон оронтой ойртон түншлэх санаачлагыг эхлэн гаргаж, идэвхтэй үйл хөдлөлд орсон юм. Энэхүү манай талын бодлого, санаачлага, үйл ажиллагаа нь тухайн цаг үеийн дотоод, гадаад бодит нөхцөл байдал, зайлшгүй шаардлагаас урган гарсан билээ. Тийм байдал нь бас хэдэн гол учир холбогдолтой байна. Нэг талаар, 1990-ээд оны эхнээс хуучны социалист орнууд, ялангуяа ЗХУ-тай явуулж байсан манай улсын эдийн засгийн хамтын ажиллагаа, гадаад худалдааны цар хэмжээ эрс буурсан, зээл тусламжийн арга хэмжээ үндсэндээ байхгүй болсон. Тухайлбал, Монгол улс ЗХУ-аас авч ашигласан зээлийн хэмжээ 1986-1990 оны таван жилд 3 тэрбум 589 сая шилжих рубльд хүрсэн байв. Тэр их хэмжээтэй хөрөнгийн эх үүсвэр 1991 оноос эхлэн гэнэт тасалдаж манай нийгэм, эдийн засаг, хүн ардын аж амьдрал ихээхэн хүндрэлд ороход айхавтар нөлөөтэй байсан юм. Нөгөө талаар, манай улс дотоодлоо өөрчлөлт шинэтгэлийн үйл хэргийг сайтар бодож боловсруулсан бодлого чиглэлгүй, хийсвэр ойлголт, хийрхэл хөөрөлд хэт хөтлөгдөн, буруу

ташаа арга барилаар явуулах гэж оролдсоноос болж нийгэм-эдийн засаг гүнзгий хямралд орж, асар их хүндрэл бэрхшээлтэй гэнэт тулгарсан билээ.

Тийм төвөгтэй болсон цаг үед онгойж эзгүйрсэн их хэмжээний зээл тусламжийг хаанаас олох вэ гэдэг асуудал тулгарсан тул тэр үеийн төр засгийн тэргүүн байсан П.Очирбат, Д.Бямбасүрэн нар Герман, Франц, Япон зэрэг горьдлоготой байж магадгүй гэсэн томоохон улсуудад хэдэн тэрбумаар нь долларын зээл хүссэн бичиг захидал илгээж, заримд нь өөрсдийн биеэр очиж гуйж байсан юм. Тэхдээ Монгол улс нэгэнт тэдний дургүй социализмаас татгалзаж, нэн даруй халж байгаа учраас тэдгээр орон ч долларын зээл тусламжийг цутгаад өгнө гэж манай төр засгийн толгойд байсан тэр хэдэн хүн гэнэхэн бодож байсан болов уу. Мэдээж тэгж шууд л хэдэн тэрбумаар л долларын зээл тусламж хүртээгээд байх улс орнууд тийм ч амархан олдохгүй гэдэг нь ойлгомжтой байсан билээ.

Харин Монголын хүнд байдалд туслах зорилгоор хандивлагч орнууд болон олон улсын байгууллагын хамтарсан зөвлөлгөөнийг 1991 оноос эхлэн жил бүр Дэлхийн банк, Японы Засгийн газар хамтран Токёод 5 удаа зохион явуулж манай талын хүсэлтийг харгалзан оролцогч орнууд, олон улсын банкны зүгээс хичнээн хэмжээний зээл тусламж олгож болох талаар ярилцаж тохиролцдог болсон билээ. Тэрхүү хандивлагчдын зөвлөлгөөнөөс жилдээ дундажаар 200-220 сая орчим ам.долларын зээл тусламж үзүүлэхээр амладаг жишигтэй явж ирсэн юм.

Гагцхүү хандивлан тэтгэгч орнууд, олон улсын байгууллагын нийт зээл тусламжийн 30 гаруй хувь нь дангаараа Японд ноогдож байдаг ажээ. Эл байдалтай холбогдуулан дашрамд дурьдахад үнэндээ АНУ мэтийн өрнөдийн өндөр хөгжилтэй томоохон орнууд бол Монголын улс төрийн тодорхой бүлэг хүчнийг дэмжин ардчилал, зах зээл хэмээх ерөнхий чиглэлд түлхэхээс биш, уг үйл явцыг яаруу давчуу бөгөөд буруу арга хандлагаар явуулсанаас шалтгаалж хүндэрсэн эдийн засаг, ард түмний амьжиргаанд мэдэгдэхүйц тус өгөөжтэй, томоохон хэмжээний тусламж дэмжлэг үзүүлэх нь хомс, Японтой харьцуулбал “бид аахилая, та нар хийж бай” гэх янзтай байгаа билээ. Түүгээр ч барахгүй барууны баян орнуудын төр засгийн төлөөний хүмүүс, өөрсдийнх нь бүтэлгүй зөвлөмж, болгоомжгүй шахалтын нөлөөгөөр /мэдээж хий хөөрцөгдсөн

монголчууд бидний буруугаар/ Монголын нийгэм, эдийн засаг хямрал уналтанд орсон, ард түмний ихэнх хэсгийн аж амьдрал доройтсон өнөө үед болохоор Японы талд, танайх яах гэж Монголд их хэмжээний зээл тусламж үзүүлээд байгаа юм бэ гэсэн асуулт, нэг ёсондоо тэдний тусламжийг багасгуулах утгатай шаардлага тавьж байгаа сураг сонсогдож байгаа нь Монгол улсыг ядууруулаад тэр аянд нь орхих гэсэн санаархал гэж ойлгогдож болох юм.

Түүнчлэн Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Олон улсын валютын сангаас багаахан хэмжээний зээл, тусламж үзүүлж ирсэн боловч манай Монгол улсын өвөрмөц онцлог, шилжилтийн үеийн нөхцөл байдалд төдийлэн тохирохгүй, бэлтгэл хангагдаагүй, монголчууд бидний өнөөгийн түвшин хүрэхээргүй олон болзол, шаардлага тавьдаг, тэр нь эргээд нийгэм, эдийн засгийн амьдралд сөрөг нөлөөтэй болсон юм. Тэдгээр олон улсын байгууллагын зээл тусламж нь манай орны эдийн засаг, үйлдвэрлэлийн хөгжилд бодит тус дэм багатай, гол төлөв элдэв төсөл нэрээр бичиг цаас боловсруулахад, тэдний мэрэгжилтний цалин хангамжийн төлбөрт зарцуулагддаг гэсэн ойлголт, шүүмжлэлтэй хандлага нилээд байдаг билээ.

Япон улсаас манай оронд үзүүлж буй зээл тусламжийн хэмжээ ахиутай байгаагийн нэгэн гол учир холбогдол бол Монголын талаас нийгэм, эдийн засгийн амьдралд нэн чухал нөлөөтэй бөгөөд зах зээлийн тогтолцоонд шилжих оролдлого хийх явцад ихээхэн хүндэрч яах аргагүй шахам болж байгаа олон салбар, чиглэлээр зээл тусламж авах хүсэлтээ Японы Засгийн газарт тун шургуу тавьдаг үйл ажиллагаатай холбоотой байна. Түүнчлэн 1990 оноос хойш Монголын төр засгийн эрхэнд гарсан зүтгэлтнүүд, ажил хэргийн хүмүүс, хуучны ЗХУ болон бусад социалист гэгдэж байсан орнуудтай хийж байсан хамтын ажиллагааны онгойсон их орон зайг нөхөх боломжийг эрж хайхдаа Япон улсад илүүтэй найдвар тавьж байсан нь тодорхой юм. Үүнд юуны өмнө улс төрийн харилцааг дээд түвшинд байлгахыг эрмэлзэн Монгол улсын Ерөнхийлөгчийн албан ёсны болон ажлын айлчлал 2 удаа, Улсын Их хурлын даргын айлчлал 1 удаа, Ерөнхий сайдын айлчлал 4 удаа болсон, Монголын талаас хоёр улсын харилцааг иж бүрэн түншлэлийн түвшинд хүргэх санал тавьсаны үндсэн дээр тийм агуулгатай баримт бичиг гаргасан билээ.

Сүүлийн арваад жилд Монгол улс Япон улсаас нилээд их

хэмжээний зээл тусламж авсан, тэр хөрөнгөөр манай орны хувьд аминд тулсан олон чухал арга хэмжээг хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлж байгаа нь олон түмний нүдэнд илэрхий тусаж, анхааралд өртөх нь аргагүй элбэг байдаг болов уу. Гэхдээ Монгол, Япон хоёр улсын хамтын ажиллагааны тэр бүх арга хэмжээ нь дандаа л манай талын санал хүсэлтийн үндсэн дээр хийгдэж байдаг бодит үнэнийг бид бүхэн зохих ёсоор ойлгож байвал зохилтой байх сан.

Үүнтэй холбогдуулан цохож тэмдэглэмээр, анхаарууштай зүйл бол хоёр улсын хамтын ажиллагааны арга хэмжээ, зээл тусламжийн асуудал нь манай Монголын талаас яам газруудын хүсэлтээр, Засгийн газрын шугамаар албан ёсоор тавьж, олон дахин санал хүсэлт, үндэслэл нотлогоо гаргаж байж, Японы тал нарийвчлан судлаж үзсэний үндсэн дээр зөвшөөрүүлж тохиролцсон байдаг юм. Гэтэл манай Монголын зарим цөөн хүмүүсийн зүгээс ер нь Япон яагаад манайд ингэж “элэгтэй” хандаад, тусламж үзүүлээд байгаа юм, цаанаа ямар нэгэн учир байна уу гэж эргүүлэн сэрлэх байдлаар хандах явдал ажиглагдаж байдаг нь үзэгдэл юмсын зүй тогтолцоо, уялдаа авцалдаа, учир зүйн үүднээс авч үзвэл тун ойлгомжгүй, бодол ухаарал муутай, ухвар мөчидхөн хандлага болж таарах болов уу.

Гуравдахь учир холбогдолын тухайд Японы талд хамааруулан авч үзэж болох юм. Манай хоёр орны хооронд хөгжиж байгаа харилцаа, хамтын ажиллагааны оролцогч нөгөө тал нь Япон улс учраас мэдээж учир хамааралтай байж таарах бөгөөд тэр талаархи өөрийн бодлыг тайлбарлан өчсүү. Энд юуны өмнө Япон бол өөрөө Азийн орон гэдэг нь чухал учир холбогдолтой хүчин зүйл байж болох юм. Япон улс Ази тивийн орнуудад, тэдний хүн ардад илүүтэй ханддаг ч гэх юмуу, ямар ч гэсэн эхний хамаарал хүрээнд тавьдаг нэгэн хандлага тодхон ажиглагдаж байдаг билээ. Үүнийг тун энгийн баримт жишээгээр хэлж болох юм. Осака хотын Гадаад судлалын Их сургуульд гадаадын 30-аад орноос уригдсан багш нар ажилладаг бөгөөд тус сургуулийн хичээлийн шинэ жилийн нээлтийн ёслолын хуралдаанд гадаадын багш нарыг оролцуулахдаа тайзан дээр эхний эгнээнд Азийн нэгдэх бүлэг орны буюу Хятад, Солонгос, Монгол, Индонези гэсэн дэс дарааллаар багш нарыг суулгаж, тэднээс эхлэж танилцуулдаг тогтсон журамтай байна. Европ, Америкийн том орнуудаас ирсэн багш нар тэртээ арын эгнээнд сууж байх жишээтэй байдаг. Японд дэлхийн улс

орныг тив бүсээр ангилан бүлэглэхдээ Ази тивээс эхлэдэг, тэр дотор Монгол улс бүр Азийн нэгдүгээр бүлэг оронд багтдаг ажээ.

Мөн өөр нэгэн баримтыг дурьдвал, хэдэн жилийн өмнө Японд дэлхийн шинэхэн үеийн түүхээр 38 боть ном хэвлэгдсэний I боть нь Японы түүх, II боть нь Хятадын, III боть нь Солонгосын, IV боть нь Монголын түүхийн ном байлаа. Ийнхүү дэлхийн гол, томоохон улс орнуудын шинэхэн үеийн түүхийн олон боть ном хэвлэхдээ Азийн нэгдүгээр бүлэг орнуудын түүхийн ботиудад эхний дугаар өгсөн нь тохиолдлын чанартай биш, угаасаа тогтсон журмын дагуу хийгдсэн ажил бололтой.

Япон дахь Азийн талаархи иймэрхүү үзэл бодол нь угаасаа дээр үеэс Европын зүгээс Азийн улс үндэстнийг дорд үздэг, мөн ялагдаж дарлагдаж ирсэн түүхэн үйл явцтай холбоо хамааралтай байж болох тухай хувийн бодол, дүгнэлт төрж байдаг юм. Мөн тиймэрхүү байдлаар тайлбарладаг эрдэмтэн болон жирийн хүмүүс ч хааяа тааралдана. Ер нь европынхны зүгээс иймэрхүү хандлага байдаг нь Ази хүний хувьд монголчууд бидэнд ч окутан ахуй цагаас эхлэн мэдрэгдэж байсан билээ.

Японд XIX зууны сүүлчээр Мэйжийн шинэтгэлийн үеэс Их Азийн үзэл санаа, Азийг хүчирхэг болгох, Азийн улс орнуудын хүчийг нэгтгэх бодлого чиглэл бий болж, өнгөрсөн зууны эхнээс 1930-аад он, улмаар II дайныг дуустал баримтлаж байсан бололтой юм. Япон улс 1890 онд Манж Чин улстай, 1905 онд Оростой дайн хийж ялсан зэрэг нь хүчээ сорьсон хэрэг байсан, мөн Солонгос, Хятад, Манжуур, Өвөр монголыг эзэлсэн зэрэг үйл явдлыг тэр үеийн Японы төр засгийн удирдлагын зүгээс бол Азийг нэгдмэл хүчтэй болгох бодлого, зорилготой хэмээн тайлбарлаж, түүнд нь японы жирийн олон түмэн ч үнэмшиж, олон тооны япон хүмүүс тэдгээр орнуудад очиж нутгийн хүн ардтай хамтдаа амьдарч байсан ажээ. Тэгээд дэлхийн II дайн дууссаны дараа япончууд Азийг тийм аргаар нэгдмэл хүчтэй болгох бодлого нь буруу чиглэл байсан гэдгийг ойлгосон, тэгж үзэхээ больсон хэмээн түүх шастираа, тэр үеийн үйл явдлын учир холбогдлыг мэдэх японы эрдэмтэн хүмүүс тайлбарлан ярьдаг юм билээ.

Тэгээд Япон дэлхийн дайнаас хойш АНУ-ын нөлөө дэмжлэгтэйгээр богино хугацаанд түргэн хөгжиж, Азийн хамгийн өндөр хөгжилтэй, дэлхийд техникийн дэвшил, эдийн засгийн чадавхи, чөлөөт валютын нөөцөөр тэргүүлэх орны нэг болж, Азийн орнуудын

хөгжилд эдийн засгийн тусламж, дэмжлэг үзүүлдэг, хамтын ажиллагаа явуулдаг хүчирхэг орон болсон нь нийтэд тодорхой юм.

Япон улсаас гадаад орнуудад үзүүлдэг тусламж, эдийн засгийн хамтын ажиллагаа нь дөрвөн төрлийн хэлбэрээр явагддаг ажээ. Үүнд: нэгд, хөгжлийн албан ёсны тусламж, хоёрт, Засгийн газрын бусад сан, гуравт, хувийн элдэв сан, дөрөвт, хувийн чөлөөт агентлагуудын батлагаа гэж ангилагдана. Хөгжлийн албан ёсны тусламжийн хүрээндээ бусад олон орнуудтай өргөн цар хүрээтэй хамтын ажиллагаа явуулдаг байна. Япон улс гадаад орнуудад үзүүлдэг нийт тусламж, хамтын ажиллагааны хэмжээгээр аль хэдийн дэлхийд 1 байранд орох болсон, энэ талаар мөн дэлхийд дөрөвт ордог АНУ-ынхаас 2 дахин их хэмжээтэй байдаг ажээ. Японы гадаад оронд үзүүлдэг тусламж, хөнгөлөлтэй зээлийн нийт хэмжээ 1990-ээд оны дунд үе гэхэд жилдээ 28,5 тэрбум орчим доллар болсоны дотор Засгийн газрын шугамаар үзүүлдэг хөгжлийн албан ёсны тусламж 13,3 орчим тэрбум доллар, мөн Засгийн газрын бусад тусламж 3,2 тэрбум долларт хүрсэн байжээ.

Тус орны хөгжлийн албан ёсны тусламж дэлхийн бүс нутгийн чиглэлээр хуваарилагдсан байдлыг авч үзвэл мөнөөх Ази тивд 1970 онд 98,3 хувь нь, 1990 онд 70,6 хувь нь ноогдож байсан бол харин 1994 онд 57,3 хувь болсон байв. Тэгэхээр Япон улс 1970-аас 1990-ээд оны эхэн үе хүртэл Ази тивийн олон улс орнуудад ахиу хувь хэмжээтэй тусламж үзүүлж ирсэн нь ойлгомжтой болж байна.

Монгол, Японы хооронд 1988-1989 оны үед хамтын ажиллагаа эхлэх тухай ярилцаж байхад Монгол улсын нэг хүн амд ноогдох үндэс ний орлого 950 доллараас бага байвал Японы хөгжлийн албан ёсны тусламж үзүүлдэг тогтсон журамтай байдаг хэмээн ерөнхий шалгуурын түвшингээ бидэнд мэдэглэж байсан юм. Тэгээд Японы Засгийн газар Монгол улсыг 1990-ээд оны эхнээс албан ёсны тусламжийн хүрээндээ оруулсанаар бидний дээр дурьдсан тусламж дэмжлэгийг үзүүлэх болсон билээ.

Монголд үзүүлж буй тусламжийн хэмжээ нь тэдний гадаад орнуудад үзүүлдэг тусламжийн нийт дүнд харьцуулан үзвэл тун ялихгүй хувь ноогдож байгаа нь мэдээж юм. Ингэж хэлсэнээрээ Япон улсаас манай Монголд үзүүлж байгаа тусламж дэмжлэгийг чамлах санаа өвөрлөсөн хэрэг огтхон ч биш бөгөөд харин ч Японы гадаад улс орнуудад үзүүлж буй тусламжийн хэмжээг

тэдний хүн амынх нь тоонд харьцуулсан түвшингээр авч үзвэл Монгол улс нилээд дээгүүр байранд ордог ажээ. Тийм болохоор нэгд, Японы тусламж “ихдээд” эдийн засгийн аргаар эзлэгдэж юуны магад гэж эмээх явдал эдүгээ ядууралд нэрвэгдээд байгаа Монгол орны хувьд нэг их баймааргүй, хоёрт, Япон орны эдийн засгийн өнөөгийн таагүй байдлаас шалтгаалан манайд үзүүлж буй тусламжийн хэмжээ бүү хорогдоосой хэмээн залбирч байх нь зүйтэй ч байж мэднэ.

Япон улс татвар төлөгч олон түмнийхээ орлогоос гадаад орнуудад тусламж үзүүлэхдээ мэдээж дэлхий дахинаа өөрийн улсын нэр хүндийг өргөх, зах зээлээ өргөжүүлэх, компаниудынх нь орлого нэмэгдэх зэрэг эрх ашиг давхар байгаа гэдэг нь ойлгомжтой, тийм байхаас ч өөр аргагүй болов уу.

Манай хоёр улсын харилцаанд нөлөөтэй Японы талын бас нэгэн чухал учир холбогдол бол жирийн олон япон хүмүүс манай оронд монголын хүн ардад элгсэг дотно харьцдаг хандлага юм. Тааралдсан үл таних япон хүмүүс аль улс үндэстний хүн бэ гэж асуухад нь монгол хүн гэж хэлэхээр нүүр царайнд нь баясал төрөөд дотно байдалтай болох нь олонтой ажиглагддаг. Япангуяа манай малчдын өвөрмөц ажил үйлс, амьдрал ахуйн арга ухааныг ихээхэн сонирхож байдаг юм. Тийм ч учраас Японы Засгийн газрын бодлого, чиглэлтэй хамааралгүй жирийн олон хүмүүс, муж, хот, нийгэмлэг компаний шугамаар үзүүлдэг сайн санааны тусламж дэмжлэг нилээд байдаг.

Энэ бүхэн нь Монгол, Японы харилцаа өргөжин хөгжиж буй өнөөгийн нөхцөлд манай зарим хүмүүсийн “гайхлыг” төрүүлээд байдаг Японы талд хамаарах учир холбогдол мөн болов уу хэмээн бодном.

Эцэст нь нэгэн зүйлийн санаа бодлоо толилуулбал, өнөөгийн Монгол, Японы харилцаа, хамтын ажиллагаа жинхэнэ түншлэлийн түвшин хэмжээнд хүрээгүй байгаа, цаашид ихээхэн ахиулах нь зүйтэй хэмээн бодогдоно. Энэ нь Монгол улсын эрх ашигтай холбоотой юм. Одоогоор хоёр улсын төр засгийн түвшинд харилцаа гайгүй сайн байгаа боловч хувийн хэвшлийн хүрээнд хамтын ажиллагаа олигтой зүгшрээгүй, хөрөнгө оруулалт, зээлийн харилцаа хомс байна. Үүнд манай орны дэд бүтэц хангалтгүй, банкны ажиллагаа найдваргүй, дотоодын зах зээлийн багтаамж бага, хүмүүсийн ажил хэрэгч чанар сул байгаа зэрэг таагүй нөхцөл

байдал, хүчин зүйлс голлон нөлөөлж байна.

Монгол, Япон хоёр улсын хооронд харилцаа, хамтын ажиллагааг цаашид бүх хүрээ хэлбэрээр хөгжүүлэхэд төр засаг, олон нийтийн байгууллага, хувийн хэвшил, жирийн хүмүүсийн хооронд харилцан ойлголцол ихээхэн ач холбогдолтой байх болно. Энэ бол аль ч улс орны харилцаанд хамгийн чухал хүчин зүйл юм. Хэрэв бие биенээсээ цэнэж болгоомжлоод, хардаж сэрдээд байвал харилцан ойлголцол, итгэлцэл, хэвийн сайн харилцаа төлөвшин бүрэлдэхэд төвөгтэй болох нь мэдээжийн хэрэг билээ.

Тэхээр энд дурьдсан гурван талын учир холбогдлын үндсэн дээр Монгол, Япон хоёр улсын хооронд харилцаа, хамтын ажиллагаа чухамдаа иж бүрэн түншлэлийн хэмжээнд хүртэл өргөжин хөгжиж байхад тун гэмгүй болов уу хэмээн бодох юун.